



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СБА-2022/02/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Баруун-Урт
2022 он

Сүхбаатар аймаг дахь төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Нарантуяа

Утас: 99029193

Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Даваа

Утас: 99035990

Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК

Захирал: А.Сарангэрэл

Утас: 9988 4842

Цахим хаяг: gereltekhburtgelaudit03@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	16
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
4. Аудитын илрүүлэлт	17
4.1 Залруулсан алдаа.....	17
4.2 Төлбөрийн акт.....	18
4.3 Албан шаардлага	18
4.4 Зөвлөмж.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар



**СҮХБААТАРАЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2022.02.25 № 109

танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
П.МӨНХЖАРГАЛ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *М.Нарантуяа* М.НАРАНТУЯА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	135,589,521.25	2,868,143,105.97
33	АВЛАГА	11,091,505.20	64,157,791.20
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		-
335	Бусад авлага	11,091,505.20	64,157,791.20
3351	Байгууллагаас авах авлага	9,091,505.20	62,157,791.20
3352	Хувь хүмүүсээс авах авлага	2,000,000.00	2,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	124,498,016.05	2,803,985,314.77
354	Хангамжийн материал	124,498,016.05	151,082,614.77
35410	Бичиг хэргийн материал	26,893,411.02	20,500,656.74
35420	Аж ахуйн материал	11,176,790.03	15,453,881.03
35430	Сэлбэг хэрэгсэл	12,360,000.00	30,960,000.00
35440	Түлш, шатах тослох материал	2,720,000.00	2,410,000.00
35470	Бусад хангамжийн материал	71,347,815.00	81,758,077.00
35500	Биологийн хөрөнгө		2,652,902,700.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,853,616,796.74	5,750,540,491.06
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,781,976,796.74	5,678,900,491.06
392	Биет хөрөнгө	1,781,976,796.74	5,678,900,491.06
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,475,383,365.37	5,335,383,365.37
39202	Хуримтлагдсан элэгдэл	(143,317,988.30)	(204,817,038.95)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	583,405,000.00	669,955,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(405,430,967.10)	(455,440,967.02)
39205	Машин тоног төхөөрөмж	891,911,032.00	996,548,121.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(728,098,250.58)	(756,581,878.73)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	318,084,492.45	322,008,914.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(209,959,887.10)	(228,155,024.61)
393	Биет бус хөрөнгө	71,640,000.00	71,640,000.00
39301	Програм хангамж	15,848,800.00	15,848,800.00
39302	Хасагдуулга	(15,848,800.00)	(15,848,800.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	71,640,000.00	71,640,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,989,206,317.99	8,618,683,597.03
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	8,326,506.00	61,392,792.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	8,326,506.00	61,392,792.00
413	Өглөг	8,326,506.00	61,392,792.00
4136	Бусад өглөг	8,326,506.00	61,392,792.00
41361	Байгууллагад төлөх өглөг	8,326,506.00	61,392,792.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,980,879,811.99	8,557,290,805.03
51	Засгийн газрын хувь оролцоо	1,980,879,811.99	8,557,290,805.03
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	802,637,702.25	802,637,702.25
51101	Өмч: - төрийн	802,637,702.25	802,637,702.25
512	Хуримтлагдсан үр дүн	249,399,190.33	6,825,810,183.37
51210	Өмнөх үеийн үр дүн	249,399,190.33	249,399,190.33
51220	Тайлант үеийн үр дүн		6,576,410,993.04
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	928,842,919.41	928,842,919.41
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,989,206,317.99	8,618,683,597.03

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,422,080,660.86	11,144,179,789.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	564,153,280.86	7,895,501,981.00
120	Нийтлэг татварын бус орлого	564,153,280.86	7,895,501,981.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	564,153,280.86	7,895,501,981.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,017,390.00	11,790,524.00

Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	548,135,890.86	7,883,711,457.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,857,927,380.00	3,248,677,808.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	656,688,980.00	888,997,108.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	10,000,000.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	310,274,300.00	126,418,978.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	282,374,545.00	734,201,690.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	54,040,135.00	28,376,440.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,201,238,400.00	2,359,680,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,201,238,400.00	2,359,680,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,907,266,159.97	3,667,768,795.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,907,266,159.97	3,667,768,795.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,744,984,982.80	3,400,072,819.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,127,762,508.47	991,860,109.84
210101	Үндсэн цалин	765,259,572.76	642,859,993.32
210102	Нэмэгдэл	72,370,264.21	220,385,121.08
210103	Унаа хоолны хөнгөлөлт	36,895,271.50	77,213,700.81
210104	Урамшуулал		28,953,442.63
210105	Гэрээт ажлын хөлс	253,237,400.00	22,447,852.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	141,901,244.36	121,004,187.46
210201	Тэтгэврийн даатгал	97,364,147.25	85,660,449.12
210202	Тэтгэмжийн даатгал	10,965,799.11	9,014,085.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,952,399.48	7,164,227.98
210204	Ажилгүйдлийн даатгал	2,238,099.30	1,742,916.24
210205	Эрүүл мэндийн даатгал	22,380,799.22	17,422,508.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	205,395,210.00	208,033,074.00
210301	Гэрэл, цахилгаан	19,799,993.00	43,324,817.00
210302	Түлш, халаалт	176,833,800.00	152,378,805.00
210303	Цэвэр, бохир ус	8,761,417.00	12,329,452.00
2104	Хангамж, бараа материалын зардал	120,853,079.65	108,080,979.28
210401	Бичиг хэрэг	51,613,961.65	36,629,269.28
210402	Тээвэр, шатахуун	53,265,006.00	53,370,110.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,607,612.00	12,829,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,366,500.00	1,340,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		3,912,000.00
2105	Нормативт зардал	13,460,967.00	7,804,769.00
210502	Хоол, хүнс	8,252,384.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,208,583.00	7,804,769.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	49,634,556.00	140,227,320.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	361,400.00	9,972,200.00
210602	Тавилга		1,600,000.00
210604	Урсгал засвар	49,273,156.00	128,655,120.00
2107	Томилолт, зочны зардал	11,760,357.00	17,980,000.00
210702	Дотоод албан томилолт	11,760,357.00	17,980,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,598,553.00	306,881,811.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		278,120,004.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	1,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	5,992,050.00	4,457,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	885,100.00	882,357.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	261,000.00	179,000.00

Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,786,000.00	20,638,310.00
210807	Газрын төлбөр	429,840.00	429,840.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,236,563.00	674,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,061,618,507.32	1,498,200,568.68
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,766,214,371.00	1,275,575,533.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,848,120.00	9,515,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	281,556,016.32	213,109,735.68
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	162,281,177.17	267,695,976.70
2132	Бусад урсгал шилжүүлэг	138,462,070.00	99,229,873.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	6,277,500.00	901,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	61,674,583.00	31,513,763.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	70,509,987.00	66,814,610.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	-
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө	-	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
261090	Хөрөнгийн	-	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	23,819,107.17	168,466,103.70
	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		61,581,802.00
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	-	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,819,107.17	106,884,301.70
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(485,185,499.11)	7,476,410,993.04
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	50,736,052.70	900,000,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	50,736,052.70	900,000,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(50,736,052.70)	(900,000,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(535,921,551.81)	6,576,410,993.04

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

					/Төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 01-р сарын 1-нээрх үлдэгдэл	802,637,702.25	928,842,919.41	785,320,742.14	2,516,801,363.80
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	802,637,702.25	928,842,919.41	785,320,742.14	2,516,801,363.80
C07	Тайлант үеийн үр дүн			(535,921,551.81)	(535,921,551.81)
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	802,637,702.25	928,842,919.41	249,399,190.33	1,980,879,811.99
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	802,637,702.25	928,842,919.41	249,399,190.33	1,980,879,811.99
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	802,637,702.25	928,842,919.41	249,399,190.33	1,980,879,811.99
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	6,576,410,993.04	6,576,410,993.04
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	802,637,702.25	928,842,919.41	6,825,810,183.37	8,557,290,805.03

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,926,157,937.00</u>	<u>3,268,794,838.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,017,390.00	11,790,524.00
120	Нийтлэг татварын бус орлого	16,017,390.00	11,790,524.00
120	Нийтлэг татварын бус орлого	16,017,390.00	11,790,524.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16,017,390.00	11,790,524.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,017,390.00	11,790,524.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,910,140,547.00	3,257,004,314.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	708,902,147.00	897,323,614.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	10,000,000.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	362,487,467.00	134,745,484.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	282,374,545.00	734,201,690.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	54,040,135.00	28,376,440.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	2,201,238,400.00	2,359,680,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	2,201,238,400.00	2,359,680,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,858,254,287.00</u>	<u>3,244,701,908.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,858,254,287.00	3,244,701,908.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,684,739,720.83	2,975,977,317.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,127,762,508.47	991,860,109.84
210101	Үндсэн цалин	765,259,572.76	642,859,993.32
210102	Нэмэгдэл	72,370,264.21	220,385,121.08
210103	Унаа хоолны хөнгөлөлт	36,895,271.50	77,213,700.81
210104	Урамшуулал		28,953,442.63
210105	Гэрээт ажлын хөлс	253,237,400.00	22,447,852.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	-	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	141,901,244.36	121,004,187.46
210201	Тэтгэврийн даатгал	97,139,447.25	84,313,459.88
210202	Тэтгэмжийн даатгал	11,190,499.11	9,014,085.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,952,399.48	7,164,227.98
210204	Ажилгүйдлийн даатгал	2,238,099.30	1,742,916.24
210205	Эрүүл мэндийн даатгал	22,380,799.22	18,769,497.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	205,395,210.00	207,153,074.00
210301	Гэрэл, цахилгаан	18,620,505.00	18,491,437.00
210302	Түлш, халаалт	176,833,800.00	177,212,185.00
210303	Цэвэр, бохир ус	9,940,905.00	11,449,452.00
2104	Хангамж, бараа материалын зардал	80,843,831.00	85,852,745.00
210401	Бичиг хэрэг	18,328,723.00	12,493,693.00
210402	Тээвэр, шатахуун	45,518,966.00	52,340,110.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,629,642.00	14,075,162.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,366,500.00	1,940,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		5,003,780.00
2105	Нормативт зардал	4,970,910.00	7,996,792.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,970,910.00	7,996,792.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	36,743,140.00	63,549,931.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,906,120.00	14,999,921.00
210602	Тавилга		5,538,000.00

Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210604	Урсгал засвар	24,837,020.00	43,012,010.00
2107	Томиллолт, зочны зардал	11,760,357.00	17,980,000.00
210702	Дотоод албан томиллолт	11,760,357.00	17,980,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,598,553.00	293,986,005.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		282,311,508.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	1,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	5,992,050.00	4,457,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	885,100.00	882,357.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	261,000.00	179,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,786,000.00	3,551,000.00
210807	Газрын төлбөр	429,840.00	429,840.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,236,563.00	674,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,062,763,967.00	1,186,594,473.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,048,915,847.00	1,176,822,673.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,848,120.00	9,771,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	173,514,566.17	268,724,590.70
2132	Бусад урсгал шилжүүлэг	141,368,953.00	100,258,487.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	6,277,500.00	901,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	61,674,583.00	31,513,763.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	73,416,870.00	67,843,224.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	32,145,613.17	168,466,103.70
213401	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	61,581,802.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	32,145,613.17	106,884,301.70
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>67,903,650.00</u>	<u>24,092,930.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	67,903,650.00	24,092,930.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	67,903,650.00	24,092,930.00
2200	Дотоод эх үүсвэрээр	67,903,650.00	24,092,930.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	67,903,650.00	24,092,930.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(67,903,650.00)</u>	<u>(24,092,930.00)</u>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,532,350,500.00	2,264,586,922.30	267,763,577.70	89.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,532,350,500.00	2,264,586,922.30	267,763,577.70	89.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,340,560,700.00	2,164,328,435.30	176,232,264.70	92.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,079,029,800.00	975,808,995.84	103,198,856.16	90.43
210101	Үндсэн цалин	636,000,000.00	626,808,879.32	9,191,120.68	98.55
210102	Нэмэгдэл	252,000,000.00	220,385,121.08	31,614,878.92	87.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт	83,760,000.00	77,213,700.81	6,546,299.19	92.18
210104	Урамшуулал	84,800,000.00	28,953,442.63	55,846,557.37	34.14
210105	Гэрээт ажлын хөлс	22,469,800.00	22,447,852.00	21,948.00	99.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	144,634,500.00	118,903,967.46	25,730,532.54	82.21
210201	Тэтгэврийн даатгал	101,473,300.00	82,213,239.88	19,260,060.12	81.02
210202	Тэтгэмжийн даатгал	10,790,300.00	9,014,085.56	1,776,214.44	83.54
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,632,200.00	7,164,227.98	1,467,972.02	82.99

Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210204	Ажилгүйдлийн даатгал	2,158,100.00	1,742,916.24	415,183.76	80.76
210205	Эрүүл мэндийн даатгал	21,580,600.00	18,769,497.80	2,811,102.20	86.97
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	207,233,700.00	207,153,074.00	80,626.00	99.96
210301	Гэрэл, цахилгаан	18,500,000.00	18,491,437.00	8,563.00	99.95
210302	Түлш, халаалт	177,233,700.00	177,212,185.00	21,515.00	99.99
210303	Цэвэр, бохир ус	11,500,000.00	11,449,452.00	50,548.00	99.56
2104	Хангамж, бараа материалын зардал	88,504,700.00	85,852,745.00	2,651,955.00	97.00
210401	Бичиг хэрэг	12,504,700.00	12,493,693.00	11,007.00	99.91
210402	Тээвэр, шатахуун	53,000,000.00	52,340,110.00	659,890.00	98.75
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	16,000,000.00	14,075,162.00	1,924,838.00	87.97
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	1,940,000.00	60,000.00	97.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,000,000.00	5,003,780.00	(3,780.00)	100.08
2105	Нормативт зардал	8,000,000.00	7,996,792.00	3,208.00	99.96
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,000,000.00	7,996,792.00	3,208.00	99.96
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	88,100,000.00	87,642,861.00	457,139.00	99.48
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,000,000.00	14,999,921.00	79.00	100.00
210602	Тавилга	30,000,000.00	29,630,930.00	369,070.00	98.77
210604	Урсгал засвар	43,100,000.00	43,012,010.00	87,990.00	99.80
2107	Томилолт, зочны зардал	20,000,000.00	17,980,000.00	2,020,000.00	89.90
210702	Дотоод албан томилолт	20,000,000.00	17,980,000.00	2,020,000.00	89.90
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	300,058,000.00	293,986,005.00	6,071,995.00	97.98
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	286,308,000.00	282,311,508.00	3,996,492.00	98.60
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,016,000.00	1,500,000.00	516,000.00	74.40
210803	Даатгалын үйлчилгээ	4,484,000.00	4,457,600.00	26,400.00	99.41
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,200,000.00	882,357.00	317,643.00	73.53
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	400,000.00	179,000.00	221,000.00	44.75
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,600,000.00	3,551,000.00	49,000.00	98.64
210807	Газрын төлбөр	550,000.00	429,840.00	120,160.00	78.15
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,500,000.00	674,700.00	825,300.00	44.98
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	405,000,000.00	369,003,995.00	35,996,005.00	91.11
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	400,000,000.00	364,003,995.00	35,996,005.00	91.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,000,000.00	5,000,000.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	191,789,800.00	100,258,487.00	91,531,313.00	52.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	191,789,800.00	100,258,487.00	91,531,313.00	52.28
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	-	-	-
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	10,000,000.00	901,500.00	9,098,500.00	9.02
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	78,789,800.00	31,513,763.00	47,276,037.00	40.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	103,000,000.00	67,843,224.00	35,156,776.00	65.87
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,532,350,500.00	2,264,586,922.30	267,763,577.70	89.43
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,517,350,500.00	2,252,796,398.30	264,554,101.70	89.49

Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,517,350,500.00	2,252,796,398.30	264,554,101.70	
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	15,000,000.00	11,790,524.00	3,209,476.00	78.60
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,000,000.00	11,790,524.00	3,209,476.00	78.60

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Тайлант оны	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	835,741,812.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	835,741,812.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	18,151,334.00	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	16,051,114.00	
210101	Үндсэн цалин	16,051,114.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,100,220.00	
210201	Тэтгэврийн даатгал	2,100,220.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	817,590,478.00	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	812,818,678.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,771,800.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	835,741,812.00	
	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	134,745,478.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	677,644,270.00	
	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	23,352,064.00	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд хөрөнгийн ашиглалт, цалингийн тооцоолол, татварын хуулийн хэрэгжилт, шилэн дансны хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Гэрэлтэх бүртгэл Аудит ХХК-ийн ахлах аудитор С.Дашдэндэв, аудитор Д.Галт-Эрдэнэ, аудиторовын туслах Э.Алтангэрэл, аудиторовын туслах Ч.Мөнхбаясгалан нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Д.Батмөнх, захирал А.Сарангэрэл, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер Г.Даваа, Дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 04/72 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газар нь аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангах стратегийг төлөвлөх, оновчтой бодлого боловсруулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулалт хийх, бодлогын хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийж үр дүнг үнэлж дүгнэх, нутгийн захиргааны байгууллагыг мэргэжлийн удирдлагаар хангах, төрийн албаны стандартыг хангуулах, иргэдэд захиргааны үйлчилгээг үзүүлэх замаар аймгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа явуулдаг, Засгийн газрын харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 2.0 хувиар буюу 78,145.3 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 62,516.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас тооцсон тул дахин тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 2.0 хувиар буюу 73,355.4 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоосон материаллаг байдлын 80 хувиар буюу 58,684.3 мянган төгрөгөөр тогтоосон. Дахин тооцсон материаллаг байдлын түвшин нь төлөвлөлтийн үе шатнаас 4,789.9 мянган төгрөгөөр буурсан байна.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газар нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн алба нь “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	11,091.5	64,157.8	53,066.3
Бараа материал	124,498.0	2,803,985.3	2,679,487.3
Үндсэн хөрөнгө	1,853,616.8	5,750,540.5	3,896,923.7
Нийт хөрөнгө	1,989,206.3	8,618,683.6	6,629,477.3
Өр төлбөр	8,326.5	61,392.8	53,066.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,980,879.8	8,557,290.8	6,576,411.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,989,206.3	8,618,683.6	6,629,477.3

Авлага дансны үлдэгдэлд 1 хувь хүнтэй холбоотой 2,000.0 мянган төгрөг, Сумдад бэлэглэсэн компьютерын 765.0 мянган төгрөг, Зах зээл ба бэлчээрийн удирдлага хөгжил төслийн гэрээний үлдэгдэл төлбөр 25,356.6 мянган төгрөг, Соёлын хэлтэст Сангийн яамнаас үзүүлсэн дэмжлэгийн 15,000.0 мянган төгрөг, Байгаль орчны яамнаас энгийн хог хаягдлын төлбөрт 16,020.0 мянган төгрөг, Тусгай зөвшөөрлийн маягтын орлого 385.0 мянган төгрөг, Өвсний агуулахын засварын үлдэгдэл төлбөр 2,310.9 мянган төгрөг, цэргийн штабын дүйцүүлэхийн мөнгөн төлбөр 2,320.0 мянган төгрөг, нийт 64,157.8 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй байна. Үүнээс 1 хувь хүнтэй холбоотой 2,000.0 мянган төгрөг, Сумдад бэлэглэсэн компьютерын 765.0 мянган төгрөг, нийт 2,765.0 мянган төгрөгийн он дамжсан авлагатай байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 2,803,985.3 мянган төгрөг болж, 2,679,487.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн. Бараа материалын данс Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэж байгаа 13 аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой дуусаагүй ажлын гүйцэтгэл 2,652,902.7 мянган төгрөг, Засаг даргын нөөц сан болон Төрийн сангаас хийгдсэн бараа материалын орлогын 244,868.2 мянган төгрөг, нийт 2,897,770.9 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хөрөнгөөр нэмэгдсэн.

Үндсэн хөрөнгийн данс 5,750,540.5 мянган төгрөг болж, 3,896,923.7 мянган төгрөгөөр өссөн. Үндсэн хөрөнгийн данс Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн Төр захиргааны 2 дугаар байрны 4-13 дугаар давхрын 4,500,000.0 мянган төгрөг, Монголын эмэгтэйчүүдийн холбооны Сүхбаатар аймаг дахь салбарын байрны төлбөрийн 190,000.0 мянган төгрөг, Албан тушаалын 4 ерөө 2 байрны 70,000.0 мянган төгрөг, Аймгийн Засаг даргын орлогчийн албан хэрэгцээний автомашины 99,500.0 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас зарласан худалдан авах ажиллагааны хүрээнд Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системд холбох тоног төхөөрөмжийн 126,440.5 мянган төгрөг, нийт 4,985,940.5 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн.

Үндсэн хөрөнгийн данс Төр захиргааны 2 дугаар байрны 4-5 давхрын эзэмшлийг Шүүхийн шийдвэрээр өмчлөлөөс хассантай холбоотой 900,000.0 мянган төгрөгийн, Орон нутгийн өмчийн газрын шийдвэрээр 54,921.9 мянган төгрөгийн хөрөнгөөр буурсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэлд Зах зээл ба бэлчээрийн удирдлага төслийн гэрээний үлдэгдэл төлбөр 25,356.6 мянган төгрөг, Сангийн яамнаас соёлын хэлтсийн үйл ажиллагааны дэмжлэгийн 15,000.0 мянган төгрөг, Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас энгийн хог хаягдлын төлбөрт сумдын татварын орлогын дансанд төвлөрүүлэхтэй холбоотой 16,020.3 мянган төгрөг, тусгай зөвшөөрлийн маягтын орлогыг үйл ажиллагаанд зарцуулахтай холбоотой 385.0 мянган төгрөг, өвсний агуулах саравч засварласан ажлын үлдэгдэл төлбөр болох 2,310.9 мянган төгрөг, урсгал засварын зарцуулалттай холбоотой 2,320.0 мянган төгрөг, нийт 61,392.8 мянган төгрөгийн өр төлбөр бүртгэлтэй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар үндсэн үйл ажиллагааны орлого 7,722,099.1 мянган төгрөгөөр өссөн.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан орлого байна. Энэ нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого өмнөх оны мөн үеэс 7,883,711.5 мянган төгрөгөөр, нэмэлт санхүүжилтийн орлого 454,827.1 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн үйл ажиллагааны зардал өмнөх оноос 239,497.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал засварын зардал байна. Энэ нь Төрийн захиргааны 1 дүгээр байрнаас төрийн байгууллагууд шилжсэнтэй холбоотой ерөө тасалгаанд засвар хийгдсэн, бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний зардалд гэрээтийн цалинг бүртгэсэнээс голлон шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,175,723.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 3,175,723.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 643,373.2 мянган төгрөгөөр бууруулж, 2,532,350.5 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,532,350.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 2,517,350.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 15,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 2,359,680.7 мянган төгрөгийн, үндсэн үйл ажиллагааны орлогоос 11,790.5 мянган төгрөгийн, нийт 2,371,471.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,264,586.92 мянган төгрөгийг зарцуулж, 106,884.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас өмнөх оны үлдэгдэл 8,326.5 мянган төгрөгийн, Зах зээл ба бэлчээрийн удирдлагын төслийн хүрээнд сумдаас 126,418.9 мянган төгрөгийн, төслийн нэгжээс 670,209.7 мянган төгрөгийн, архивын гэрээт операторын цалин, шитгэлд 18,331.7 мянган төгрөгийн, Төрийн албаны зөвлөлийн ерөнхий шалгалтын зардалд 4,640.0 мянган төгрөгийн, Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас 10,000.0 мянган төгрөгийн, Сангийн яамнаас Соёлын хэлтсийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд 15,000.0 мянган төгрөгийн, Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас энгийн хог хаягдлын төлбөрт 16,020.3 мянган төгрөгийн, Зөвшөөрлийн хураамжийн орлого 385.0 мянган төгрөгийн, Цэргийн штабын дүйцүүлэхийн мөнгөн төлбөрийн орлого 13,409.4 мянган төгрөгийн, өвс худалдан борлуулсны орлогын 13,450.0 мянган төгрөг, Дэлхийн банкны санхүүжилтээр сургалтын зардалд 132.0 мянган төгрөг, үйл ажиллагааны бусад орлогоор 1,000.0 мянган төгрөг, нийт 897,313.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс бараа үйлчилгээний зардалд 835,731.6 мянган төгрөгийг зарцуулж, авлагад 61,392.8 мянган төгрөгийг тусгаж, улсын төсөвт 189.1 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Бусад асуудлын хэсэг:

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

3.8 Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудагч ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газар нь нийт 2,862,311.5 мянган төгрөгийн 145 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 544,039.0 мянган төгрөгийн 23 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

МУЗГ-ын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 32,625.7 мянган төгрөгийн 1 алдаа зөрчилд тогтоосон төлбөрийн актыг шийдвэрлээгүй, 2 зөвлөмжийг 100.0 хувь хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт:

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	32,625.7	-	-	1	32,625.7	100.0
Албан шаардлага	-	-	-	-	-	-	-
Зөвлөмж	2	-	2	-	-	-	-
Нийт дүн	3	32,625.7	2	-	1	32,625.7	100.0

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газрын санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 8,466,419.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 7,883,711.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 6,784.1 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 29,119.6 мянган төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлж, 546,804.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Үнэ төлбөргүй шилжин ирсэн 7,883,711.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авсан хөрөнгөөр бүртгэж тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар ,, баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Төсвийн тухай хуулийн 6 зүйлийн 6.3.2 д "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, илэрхийлэн бүртгэж, тайлагнах", "эрх ба үүрэг", "толилуулга" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үнэ төлбөргүй шилжин ирсэн 7,883,711.4 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авснаар тайлагнаж залруулсан.

4.2 Төлбөрийн акт

1. Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн газрын даргыг ажлаас үндэслэлгүй халсан болохыг шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоосон бөгөөд ажилгүй байсан хугацааны 3,308.7 мянган төгрөгийн цалин, 70.2 мянган төгрөгийн тэмдэгтийн хураамжийг төсвөөс олгож, буруу шийдвэр гаргасан холбогдох этгээдээр буцаан төлүүлээгүй байна.

Энэ нь Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5 -д "Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулан бол гэм хорыг арилган байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардан гаргуулах эрхтэй", Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцаан төлүүлнэ", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

2. Сүхбаатар аймгийн Сүхбаатар ойжуулалт сум дундын ойн анги ОНӨААТҮГ-ын даргыг ажлаас үндэслэлгүй халсан болохыг шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоосон бөгөөд ажилгүй байсан 3,405.2 мянган төгрөгийг төсвөөс олгож, буруу шийдвэр гаргасан холбогдох этгээдээр буцаан төлүүлээгүй байна.

Энэ нь Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5 -д "Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулан бол гэм хорыг арилган байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардан гаргуулах эрхтэй", Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцаан төлүүлнэ", "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

4.3 Албан шаардлага

Нийт 23 аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой 29,119.6 мянган төгрөгийн худалдан авалт татварын цахим системд бүртгэгдээгүй, И баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т "Бараа ажил үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно", 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" заалт, "эрх ба үүрэг", "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгсөн.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлагын данстай холбоотой асуудал

1.1.1 Илрүүлэлт:

Хувь хүнтэй холбоотой 2,000.0 мянган төгрөгийн, Сумдад бэлгэлсэн компьютерын 765.0 мянган төгрөгийн, нийт 2,765.0 мянган төгрөгийн он дамжсан авлагатай байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасан "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д заасан "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах,,," заалт, мөн хуулийн 20.2.6-д заасан "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалт, УСНББОУС-ын үндсэн шаардлага, "эрх ба үүрэг" батламж мэдээдлийг хангахгүй байна.

1.1.2 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох заавар журам, Төсвийн тухай хуулийг мөрдөж авлага үүсгэхгүй ажиллах. Хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах ажлын хэсэг томилох, авлага барагдуулах арга хэмжээ зохион байгуулж авлагыг барагдуулах, тооцоо нийлсэн актаар баталгаажуулах

2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

2.1.1 Илрүүлэлт:

Байгууллагын дансанд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, үлдэгдэл өртөггүй 286 ширхэг 1,171,264.7 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2 "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 6.2 "Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг дараах тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна", 6.2.1 "элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ бүрэн нөхсөн бөгөөд цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон" заалт, УСНББОУС 17 "Үндсэн хөрөнгө"-д тавигдах шаардлага, "үнэлгээ ба хуваарилалт", "иж бүрэн байх", батламж мэдээдлийг хангахгүй байна.

2.1.2 Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийн бодит үнэ цэнийг тогтоож, холбогдох эрх бүхий байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх

3. Шилэн данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудаст нийт 2,862,311.5 мянган төгрөгийн 145 мэдээллийг ил тод байршуулахаас 544,039.0 мянган төгрөгийн 23 мэдээллийг ил тод байршуулаагүй зөрчилтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам", "иж бүрэн байх" батламж мэдээдлийг хангахгүй байна.

3.1.2 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах

Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт болон аудитын хуулийн этгээдэд 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал:											
1	Үнэ төлбөргүй шилжин ирсэн хөрөнгийг худалдан авсан хөрөнгөөр бүртгэж тайлагнасан.	1	7,883,711.5	1	7,883,711.5						
2	2 ажилтны цалинг нөхөн олгохдоо төсвөөс олгож, буруу шийдвэр гаргасан холбогдох этгээдээр буцаан төлүүлээгүй байна.	1	6,784.1			2	6,784.1				
3	Худалдан авалтыг татварын цахим системд бүртгэгдээгүй, И баримтаар нотлогдохгүй байна.	1	29,119.6					1	29,119.6		
4	Он дамжсан авлага бүртгэлтэй байна	1	2,765.0							1	2,765.0
5	Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна	1	-							1	-
Дүн		6	7,922,380.2	1	7,883,711.5	2	6,784.1	1	29,119.6	2	2,765.0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:											
1	Шилэн дансны цахим хуудсанд бүрэн мэдээлээгүй	1	544,039.0							1	544,039.0
Дүн		1	544,039.0	-	-	-	-	-	-	1	544,039.0
Нийт дүн		7	8,466,419.2	1	7,883,711.5	2	6,784.1	1	29,119.6	3	546,804.0